



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 280.

Улаанбаатар хот

Биет бус хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 2.1, 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Завхан аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын биет бус хөрөнгөд бүртгэлтэй, 764 метр квадрат талбай бүхий, нийт 7,640,000.00 (долоон сая зургаан зуун дөчин мянга) төгрөгийн балансын үнэтэй хавсралтад заасан орон сууцны зориулалттай газар эзэмших эрхийг данснаас хасч, Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдэлд шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Б.Нандинболор, Завхан аймгийн Засаг дарга Г.Өнөрбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө данснаас хасах, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Газар эзэмших шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133001357
12-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
280 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬА ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ДАНСНААС ХАСАХ, БҮРТГЭЛД ТУСГАХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Бүртгэсэн он	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Балансын нийт үнэ (төгрөг)	Бүртгэлд тусгах хуулийн этгээд
1	Биет бус хөрөнгө (газар эзэмших эрх, нэгж талбарын дугаар-8109013947), Завхан аймаг, Улиастай 1-р баг, Жинст, Маамын Лхагвын 1-108	2024	10,000.00	м2	764	7,640,000.00	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар
	Нийт дүн					7,640,000.00 (долоон сая зургаан зуун дөчин мянга)	